



ТҮМЭН ШУВУУТ®

**“ТҮМЭН ШУВУУТ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2020 оны 04 сарын 22-ны өдөр

№ 01/2020

Улаанбаатар хот

*Компанийн жилийн үйл ажиллагааны болон
санхүүгийн тайлангийн талаархи
Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах тухай*

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.11, 62 дугаар зүйлийн 62.1.9, “Түмэн шувуут” нээлттэй хувьцаат компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.9, 8.14 болон тус компанийн хувьцаа эзэмшигчдийн 2020 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын 01/2020 тоот тогтоолыг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТОГТООХ нь:

1. “Түмэн шувуут” хувьцаат компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг хавсралтаар баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Л.ЭРХЭМБАЯР



ТҮМЭН ШУВУУТ®

Түмэн шувуут ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит
хурлын 2020 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн
01/2020 тоот тогтоолын хавсралт

“ТҮМЭН ШУВУУТ” ХК-ИЙН 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ДҮГНЭЛТ

“Түмэн шувуут” ХК-ийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх дүгнэлт, 2019 оны зорилтуудын талаарх илтгэлийг Компанийн тухай хууль, Түмэн шувуут ХК-ийн дүрмийн хүрээнд Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэн, тус компанийн Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж байна.

“Түмэн шувуут” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь тус компанийн 2019 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцэн баталж, компанийг удирдах үйл ажиллагаандаа Сайн засаглалын зарчмууд, Компанийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж болон Хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталсан дүрмийг мөрдлөг болгож, Компанийн гүйцэтгэх удирдлагын баг нь Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр зөвлөмж, төлөвлөгөөт зорилтыг амжилттай хэрэгжүүлэн ажиллалаа.

“Түмэн шувуут” Хувьцаат компанийн 2019 оны бизнес төлөвлөгөө нь бүтээгдэхүүний чанарыг сайжруулах, нэр төрлийг нэмэгдүүлэх, олон улсын стандартад нийцсэн шинэ техник тоног төхөөрөмжийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, үйлдвэрлэлийн бүтээмжийг дээшлүүлэх, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг оновчтой зохион байгуулах, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг сайжруулах замаар борлуулалтыг нэмэгдүүлэх, санхүүгийн үзүүлэлтүүдийг сайжруулахад чиглэсэн удирдлага зохион байгуулалтын тодорхой арга хэмжээнүүдийг авч ажиллахад чиглэсэн юм.

“Түмэн шувуут” ХК 2019 онд 20,1 тэрбум төгрөгийн борлуулалтыг хийж, 3,2 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Тайлант жилд нийт 10 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсний 1,4 тэрбум Шувууны аж ахуйн өргөтгөлд, 1,7 тэрбум бордооны үйлдвэрт, 2,2 тэрбум Шингэн өндөгний үйлдвэрт, 3,3 тэрбум төгрөгийг Шинэ шувууны аж ахуйн хөрөнгө оруулалтад тус тус зарцуулсан байна.

“Түмэн шувуут” Хувьцаат Компани нь цаашдын ажлын төлөвлөгөө, үйл ажиллагаандаа дараах чиглэлийг тусган хэрэгжүүлэх нь зүйтэй гэж Төлөөлөн удирдах зөвлөлийн зүгээс үзэж байна. Үүнд:

- Компаний ажилчдад байгууллагын эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйлсийг эрхэмлэж, ажилдаа мөрдлөг болгон ажиллах арга хэмжээг зохион байгуулах
- Өөрийн компаний бусдаас ялгарах онцлог, давуу талыг ажилтан бүрт таниулан мэдүүлж, компаниараа бахархах соёлыг бий болгон төлөвшүүлэх
- Байгууллагын хүний нөөцийн чадавхийг нэмэгдүүлэх, сургалт зохион байгуулах, шинэ ажиллах хүчний нөөц бүрдүүлэх

- ТУЗ-ийн гишүүдийн чадавхийг бүрэн дүүрэн ашиглах, үйл ажиллагаандаа идэвхитэй оролцуулах төлөвлөгөө гаргах
- Компаний санхүүгийн болон үйл ажиллагааны дотоод хяналтыг сайжруулах
- Эдийн засгийн хямрал болж байгаатай холбогдуулж, үйл ажиллагааны болон эдийн засгийн хямралын төлөвлөгөө боловсруулах
- Халдварт өвчний тархалтын эрсдэл компаний үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлөх талаар эрсдэлийн үнэлгээ өгөх, маркетинг төлөвлөгөө боловсруулах
- Бордооны үйлдвэрийн бүтээгдэхүүн борлуулах маркетингийн идэвхижүүлэлтийн ажлыг төлөвлөн, зохион байгуулах
- Хувьцаа эзэмшигчдийн тоог нэмэгдүүлэх зэрэг болно.

“Түмэн шувуут”ХК-ийн гүйцэтгэх удирдлагын баг 2019 онд төлөвлөсөн зорилтоо биелүүлэхийн тулд өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн дүүрэн ашиглан ажилласан гэж Төлөөлөн удирдах зөвлөл дүгнэж байна.

“ТҮМЭН ШУВУУТ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ



ТҮМЭН ШУВУУТ®

**“ТҮМЭН ШУВУУТ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2020 оны 04 сарын 22-ны өдөр

№ 02/2020


Улаанбаатар хот

*Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
гишүүдийг сонгох тухай*

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, 77 дугаар зүйлийн 77.4, “Түмэн шувуут” нээлттэй хувьцаат компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.7, 8.14 болон тус компанийн хувьцаа эзэмшигчдийн 2020 оны 04 дүгээр сарын 22-ний өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын 01/2020 тоот тогтоолыг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТОГТООХ нь:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчдээс хамгийн олон санал авсан дор дурдсан нэр дэвшигчдийг “Түмэн шувуут” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгосугай:
 - 1.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр:
 - 1.1.1.1. Ломбо овогтой Эрхэмбаяр
 - 1.1.1.2. Балай овогтой Тунгалаг
 - 1.1.1.3. Жигжид овогтой Болд
 - 1.1.1.4. Эрхэмбаяр овогтой Баяржаргал
 - 1.1.1.5. Цэрэннадмид овогтой Рэнчинсэнгээ
 - 1.1.1.6. Эрдэнэчулуун овогтой Жаргалхүү
 - 1.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр:
 - 1.2.1.1. Агипар овогтой Бакей
 - 1.2.1.2. Цэдэв овогтой Наран-Учралт
 - 1.2.1.3. Гочоо овогтой Мөнх-Эрдэнэ
2. Хууль тогтоомж, компанийн дүрэм, компанийн засаглалын журмуудыг мөрдөж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нийт гишүүдэд үүрэг болгосугай.
3. ТУЗ-ын бүрэлдэхүүний талаар олон нийтэд мэдээлж, шинээр сонгогдсон гишүүдийн мэдээллийг Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид хүргэхийг Гүйцэтгэх захирал (Ж.Болд)-д үүрэг болгосугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /Д.Наранцэцэг/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Л.ЭРХЭМБАЯР



ТҮМЭН ШУВУУТ®

**“ТҮМЭН ШУВУУТ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2020 оны 04 сарын 22-ны өдөр

№ 03/2020

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны зардлын төсөв батлах тухай


Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13, 62.1.15, “Түмэн шувуут” нээлттэй хувьцаат компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.13, 8.4.14 болон тус компанийн хувьцаа эзэмшигчдийн 2020 оны 04 дүгээр сарын 22-ний өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын 01/2020 тоот тогтоолыг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТОГТООХ нь:

1. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны зардлын төсвийг хавсралтаар баталсугай.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах зардлыг санхүүжүүлэхийг Гүйцэтгэх захирал /Ж.Болд/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Л.ЭРХЭМБЯАР



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙН

ЦАЛИН УРАМШУУЛЛЫН ХЭМЖЭЭ

ТУЗ-ийн гишүүд	ТУЗ-ийн 1 удаагийн хуралд оролцох цалин
Ердийн гишүүд	
Ердийн гишүүд	
Ердийн гишүүд	
Ердийн гишүүд	
Ердийн гишүүд	
Ердийн гишүүд	
Ердийн гишүүд	
Хараат бус гишүүд	
Хараат бус гишүүд	
Хараат бус гишүүд	



ТҮМЭН ШУВУУТ®

**“ТҮМЭН ШУВУУТ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2020 оны 04 сарын 22-ны өдөр

№ 04/2020

Улаанбаатар хот

*Үнэт цаасны танилцуулгад өөрчлөлт
оруулахыг батлах тухай*

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15 болон тус компанийн хувьцаа эзэмшигчдийн 2020 оны 04 дүгээр сарын 22-ний өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын 01/2020 тоот тогтоолыг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Түмэн шувуут” хувьцаат компанийн үнэт цаасны танилцуулгын 71-73 дугаар хуудсанд тусгасан шинээр байгуулагдах махны чиглэлийн тахианы аж ахуйн чиглэлийг өндөглөгч тахианы аж ахуй болгон өөрчлөхийг баталсугай.
2. Махны чиглэлийн тахианы аж ахуйг шинээр байгуулахад зориулан төсөвлөсөн 3,9 тэрбум төгрөгийг өндөглөгч тахианы аж ахуйг өргөтгөн байгуулахад зарцуулахыг Гүйцэтгэх захирал /Ж.Болд/-д зөвшөөрсүгэй.
3. Хөрөнгийн зарцуулалтын тайланг Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулж байхыг гүйцэтгэх захирал /Ж.Болд/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Л.ЭРХЭМБАЯР